


3. Албан даалгаврын хэрэгжилтийг тайлагнах

3.1 Аймаг, нийслэлийн хэмжээнд аяны хүрээнд хийгдсэн үйл ажиллагаанд хяналт, үнэлгээг хийж 7 хоног бүрийн Пүрэв гарагийн 17 цагт багтаан Шадар сайдын Ажлын албанд цахимаар болон албан бичгээр ирүүлэх.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,
УЛСЫН ОНЦОЙ КОМИССЫН ДАРГА



Я.СОДБААТАР

УХА0168



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 09 сарын 07 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН
ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ХҮРЭЭНД “АМНЫ ХААЛТАА ЗҮҮЦГЭЭЕ-2”
АЯНЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалтын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр Засгийн газрын гишүүд, төрийн захиргааны төв байгууллага, агентлагууд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нар, Харилцаа холбооны зохицуулах хороонд тус тус ДААЛГАХ НЬ:

1. Мэдээлэл сурталчилгааг эрчимжүүлэх

1.1 Иргэдэд өөрсдийн хувийн бэлтгэлийг хангах, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Амны хаалтаа зүүцгээе-2” аяныг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллах;

1.2 Уг аяны хүрээнд хэвлэмэл таниулах материал болон гарын авлагуудыг төрийн болон төрийн бус байгууллагуудаар дамжуулан иргэдэд түгээх;

2. Төрийн захиргааны төв байгууллага, Аймаг, нийслэлийн Засаг дарга, нийслэлийн болон орон нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах

2.1 Төрийн захиргааны төв байгууллага уг аянд харьяа байгууллагуудыг идэвхтэй хамруулах, Монголын телевизүүдийн холбоо болон арилжааны телевизүүдтэй хамтран ажиллах;

2.2 Аймаг, нийслэлийн Засаг дарга нар тухайн бүс нутгийн телевиз, радиотой хамтран ажиллах;

2.3 Аймаг, нийслэл төрийн байгууллагууд хувийн хэвшлийн байгууллагуудтай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтын ажиллагааг бэхжүүлж тус аянд нэгтгэх, үлгэрлэн оролцуулах;